



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар A/07

Эг

**Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар захирамж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, “Чингис хаан” тэргүүн зэргийн одонт, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Пунсалмаагийн Очирбат таалал төгссөнтэй холбогдуулан 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07.00 цагаас 01 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэл сумын хэмжээнд соёл урлаг, биеийн тамир, спортын тэмцээн уралдаан, шургуу зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

2. 2025 оны 01 дүгээр 24-ний өдрийн 12:00 цагт авто машины дуут дохиог дуугаргаж, нийт төрийн албан хаагчид нэг минут зогсож хүндэтгэл үзүүлсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Төрмөнх), Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч (Р.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501011